

БАТЛАВ  
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНГӨНХУЯГ

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ЦАХИЛГААН  
ШАТ ШИНЭЧЛЭХ АЖИЛ (15, 34 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН  
ДААЛГАВАР

2024 оны 02 дугаар сарын 07

Дугаар 24/47

Улаанбаатар хот

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122 дугаар тогтоол - Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1528 дугар захирамж
2	Барилга байгууламжийн байршил	Шинэчлэх: - 15 дугаар хороо 24 дүгээр байрны 2 дугаар орц - 15 дугаар хороо 26 дугаар байр /ачааны лифт/ - 15 дугаар хороо 22 дугаар байрны 1-р орц - 15 дугаар хороо 23а байрны 4-р орц - 15 дугаар хороо 21 дүгээр байр 2 дугаар орц - 15 дугаар хороо 29 дүгээр байр /ачааны лифт/ - 34 дүгээр хороо 5б байр 2 дугаар орц  Засварлах: - 34 дүгээр хороо 19 байр 1 дүгээр орц - 34 дүгээр хороо 21 байр 1 дүгээр орц
3	Зориулалт, хүчин чадал	- Цахилгаан шатны шинэчлэл - Цахилгаан шат засварлах
4	Зураг төсөл, бүрдэл	<u>Зураг төслийн иж бүрдэл:</u> - Цахилгаан шатны зураг - Ажлын төсөв - Тайлан
5	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	<u>1 үе шаттай</u> 1. Цахилгаан шатны засварын ажил гүйцэтгэж, хүлээлгэж өгөх. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Ажил гүйцэтгэх байгууллага	- Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага.
7	Захиалагч байгууллага	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

8	Техникийн шаардлага	<p>Улаанбаатар лифт НӨҮГ-аас боловсруулсан цахилгаан шатны техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Лифтний засварын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийг баримтална.</li> <li>2. Лифтийг засварласны дараа ашиглалтад өгөхийн өмнө туршилтын ажлыг явуулахдаа захиалагч, ашиглалтын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөөлөгчдийг байлцуулан гүйцэтгэнэ.</li> <li>3. Лифтийг засварлах үе шатны ажил эхлэх дуусах бүрд захиалагч байгууллагыг байлцуулан шалгуулж шаардлага хангасан тухай акт үйлдсэний дараа цаашид хийх ажлыг үргэлжлүүлнэ.</li> <li>4. Лифтний хонгилын хэсгийн барилгын үндсэн хийц эдлэлд өөрчлөлт оруулах, хучилтын хавтанд нэмэлт ачаалал өгөх, төхөөрөмж угсрах зорилгоор эвдэж гэмтээхийг хориглоно.</li> <li>5. Зорчигчийн бүхээг болон жижүүрийн ерөө, машины ерөөний хооронд холбогдох телефон холбоотой байна.</li> </ol>
9	Ажлын зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> <li>1. Нийлүүлэгч дараах зүйлийг ажлын төлөвлөгөөнд тусгаж захиалагчид ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Гүйцэтгэх ажлын нарийвчилсан график;</li> <li>• Ажлын талбайг бэлтгэх;</li> <li>• Бараа нийлүүлэх график;</li> <li>• Ажлын талбай дээр барааг буулгах;</li> <li>• Хуучин сэлбэг хэрэгслийг буулгах;</li> <li>• Шинээр угсрах сэлбэг хэрэгслийг;</li> </ul> </li> <li>2. Нийлүүлэгч байгууллага нийлүүлэх барааны тодорхойлолт, техникийн шаардлага, түүнийг дагалдах болон ашиглалтын явцад хэрэглэгдэх хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж зэргийг Монгол хэл дээр буулгаж захиалагчид өгнө.</li> <li>3. Техникийн паспортад ажлын зураг, схем, гагнуур, суурь, далд ажил, газардуулгын зэрэг актуудыг бүрдүүлж, монгол хэл дээр буулгаж лифт ашиглагч байгууллагад хүлээлгэж өгнө.</li> <li>4. Лифтийг нийлүүлэн угсрах байгууллага ажил эхлэх зөвшөөрлийг бараа нийлүүлэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор авсан байна. <ul style="list-style-type: none"> <li>• Угсарсан шинэ лифтний туршилт тохируулгатай холбогдон гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</li> <li>• Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан авах зөвшөөрлийн асуудлыг нийлүүлэгч буюу гүйцэтгэгч хариуцна.</li> <li>• Нийлүүлэгч үе шатны ажил дууссан нөхцөл бүрд мэргэжлийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан угсралтын байдлыг шалгаж, техникийн магадлал хийж баталгаажуулан ажиглах зөвшөөрөл авна.</li> <li>• Ажлыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх норм, дүрмийн дагуу гүйцэтгэнэ.</li> </ul> </li> <li>5. Орон сууцны барилгын лифтийг шинээр засварласны дараа ашиглалтад оруулахын өмнө техникийн бүрэн туршилтыг захиалагч, гүйцэтгэгч байгууллага, хяналтын байгууллагатай хамтран хийж техникийн дүгнэлт гаргуулна. Туршилт тохируулгын зардлыг гүйцэтгэгч хариуцна.</li> </ol>

		6. Баталгаат хугацаанд ашиглагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр тасралтгүй хангах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.
10	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ХЯНАСАН  
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ  
АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 МӨНХ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.ЭНХЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН  
ТНААХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 Г.НЯМСҮРЭН